



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/1465

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.6, 40.3, 40.4, 41 дүгээр зүйлийн 41.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 80/A2260435/-НАГ/-2019/07/-НА дугаартай албан шаардлагын дагуу Мөрөн сумын 7 дугаар баг Шинэ Мөрөн худалдааны төвийн ард байршилтай Шинэ Мөрөн худалдааны төв ОНӨХК /РД:4141571/-д Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар 4971 /0.497/ м<sup>2</sup>, газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй тул аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/23 шийдвэрийн 7 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 1011730